



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/7

Улаанбаатар хот

0-5 настай хүүхэдтэй албан хаагчдын  
ажиллах хуваарь батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 3 дугаар тэмдэглэл, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлж ажиллах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор 0-5 настай хүүхэдтэй албан хаагчдыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 02 дугаар сарын 11-ны өдөр дуустал хавсралтад заасан хуваарийн дагуу ажиллуулсугай.

2. Дээрх ажлын хуваарь батлагдсантай холбогдуулан албан үүргийг бүрэн гүйцэтгүүлэн ажиллуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдалгүй явуулах, ажлын цаг ашиглалтыг үр бүтээлтэй хангаж ажиллахыг нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нийт ажилтнууд дараах чиглэлийг баримталж ажиллахыг үүрэг болгосугай;

3.1 Цахимаар ажиллаж байгаа албан хаагчид ЭЙБЛ системд ажлын цагаар идэвхтэй горимд байх;

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шуурхай штабын ахлагч, Захиргаа, удирдлагын хэлтэс /Н.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132003144

